



# БӨХӨНГИЙН МЭДЭЭ

Бөхөнгийн экологи, хамгааллын талаар мэдээлэл солилцох 6 хэл дээрх хэвлэл



Зүргийн КБТЗХН

## Олон улсад бөхөн хамгаалах өдөр явагдаж байна!

Энэ жил Бөхөн хамгаалах өдрийг Казахстан, Узбекстан болон Халимаг (ОХУ) зэрэг 3 улс анх удаа хамтран тэмдэглэлээ. Энэ хамтарсан өдөрлөгийг 2010 оны 12-р сард Ховордсон амьтдыг хамгаалах сан, СОС хөтөлбөрөөс санхүүжисж байгаа төсөл хэрэгжисж буй газрын нэг болох Уралын районд туршилага согилцох хэлбэрээр хийхээр төлөвлөсөн байна (Бөхөнгийн мэдээ 12-с хар). Олон улсын бөхөн хамгаалах өдөрлөгийг бусад улс орон, бус нутагт өргөжүүлэх шаардлагатай бөгөөд зохион байгуулагчид энэхүү арга хэмжээнд хамтран оролцох, бөхөн болон тал хээрийн экосистемийн олон улсын өдөрлөгийн арга хэмжээг хамтран тэмдэглэхийг хүссэн хүн бүхнээс хариу хүлээж байна.

### Казахстан

Казахстаны бөхөн хамгаалах өдөрлөгийг баруун Казахстаны бус нутагт КБТЗХН (Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг), Бөхөн хамгаалах холбоо (БХХ), Олон улсын амьтан ургамлын аймгийг хамгаалах нийгэмлэг (ОУАУАХН) хамтран зохион байгууллаа. Казакстанд 2010 оны 5 сард бөхөн ихээхэн хэмжээгээр хорогдсон тул бөхөн хамгаалах өдөрлөг зохион байгуулахаар сонгосон байна. Тус өдөрлөгийг “Уралын бөхөнгийн популяцийн хамгаалалд олон нийтийн оролцоог бий болгох нь” төслөөс санаачлан (Бөхөнгийн мэдээ 12-оос харна уу) зохин байгуулжээ. Бөхөн хамгаалах өдөр 4-р сарын 27-ноос 5-р сарын 4 хүртэл Казталовский, Занибекский дүүргийн 5 тосгонд (Азибай, Нурсай, Борси, Караоби, Акоба) болж өнгөрчээ.

Үргэлжлэл 2-р хуудсанд

Хэвлэлийг санхүүжүүлсэн:

# АГУУЛГА

## Гол мэдээ

Елена Бикова, Юрий Арилов, Ольга Климанова

Олон улсад бөхөн хамгаалах өдөр явагдаж байна! ..... 1

## Сүүлийн үеийн мэдээ

Кристина Роетгер

Казахстаны бөхөнг хамгаалах эн тэргүүний ажлуудыг эхлүүлэх  
үулзалт ..... 4

Бакытбек Дуйсекеев

Баруун Казахстаны бус дэхь бөхөнгийн хорогдол ..... 4

Юрий Грачев

Казахстанд 2011 онд хийгдсэн бөхөнгийн агаарын тооллогын үр дүн ... 5

Жессика Холдкрофт

Дэлхий дээрх нэн ховор зүйлийг аврах боломж

..... 6

Данара Зарболова

Хүн бүрээг бөхөнг

..... 6

хамгаалуулья!

## Хэвлэлийн мэдээ:

Хятадын бөхөнгийн тоо өслөө.

7

Казахстаны хууль хэрэгжүүлэх байгууллагууд хууль бус  
агнуурыг бууруулах үйл ажиллагаанд нэгдлээ.

Хууль бусаар бөхөн агнах шалтгаан

1-р хуудасны ургэлжлэл:



Зүршил КБТЗХН

Уг өдөрлөгт 1-4 ангийн сурагчид, багш, эцэг  
эхчүүд зэрэг нийтдээ 350 гаруй хүн оролцсон  
бөгөөд тоглоом, тэмцээн, таавар таах зэрэг үйл  
ажиллагаа явагджээ. Сургууль бүрээс  
оролцсон хүүхдүүд бөхөнгийн тухай бусад  
хүмүүсийн болон өөрсдийн зохиосон шүлгийг  
уншиж, гар урлалын зүйлсийг бэлдсэн байлаа.  
Өдөрлөгийн хүрээнд явуулж буй үйл  
ажиллагаа нь оролцогчдын экологийн ерөнхий  
мэдээгүйг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулсан  
бөгөөд оролцогчид талархалтайгаар хүлээн авч  
байв.



Зүршил КБТЗХН

## Өгүүллүд

Владимир Н. Мирошинченко

Халимагийн бөхөнгийн жил: Гол үр дүн ба цаашдын  
төлөвлөгөө ..... 9

Буянаа Чимэддорж

Баруун Монголын Их нууруудын хотгор дахь монгол  
бөхөнгийн хамгаалал ..... 10

Доминик Тиел & Конни Тиел-Егентер

Тал хээрийн нөөц газрын бөхөн хамгаалагчдын ажлаар-сэтгэлд  
хоногшсон аялал ..... 11

Сергей Сидоров

Баруун хойд Пре-Каспийд 2011 онд хийгдсэн бөхөнгийн  
мониторинг судалгааны урьдчилсан үр дүн ..... 12

Алберт Салемгареев

Бетпакдалагийн бөхөнгийн популяцийн тооллогыг хийхэд  
агаарын судалгаа, хэт улаан туяаны зураглалыг ашиглах  
туршилт ..... 14

Павел Амосов

Баскунчак нуурын бөхөн ..... 15

Чери Роадес

Бөхөн хамгаалах холбооны давуу, сүл талын дүн шинжилгээ....

16

## Бөхөнгийн баатрууд

Аслан Байделдинов, Халимагийн БНУ-ын зэрлэг амьтныг  
хамгаалах төв ..... 17

## Хэрэгжиж буй төслүүд

Бөхөн хамгаалах холбооны төслийн сүүлийн үеийн

18

мэдээ.....

## Бөхөнгийн шинэ өгүүлэл.....

19

Дэлгэрэнгүйг:

[http://acbk.kz/index.php?option=com\\_content&task=view&id=222&Itemid=311](http://acbk.kz/index.php?option=com_content&task=view&id=222&Itemid=311).

## Узбекистан

Сүүлийн хэдэн жилийн турш Бөхөн хамгаалах  
өдрийг Узбекистаны Устюртын өндөрлөгт  
тэмдэглэж байна. Энэ жил уг газарт 4 сарын 27-29-  
ны хооронд “Энэ бол бөхөн хамгаалах бидний хүч”  
уриан дор хийсэн. Кунград дүүргийн Жаслик болон  
Каракалпак зэрэг 2 тосгоныхон оролцсон бөгөөд  
үйл ажиллагааг орон нутгийн сургуулиуд зохион  
байгуулж, Бөхөн хамгаалах холбоо, ОУАУАХН  
санхүүжүүлэн, сургуулийн хүүхдүүд, орон нутгийн  
оршин суугчид, орон нутгийн шийдвэр гаргагчид,  
байгаль орчин болон хууль хэрэгжүүлэх албаныхан,  
төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийнхэн



Зүрэгийн А.Есипов

оролцсон. Тосгоны зөвлөл, сургуулийн захирлууд оролцогчдыг урьж төрөлх газар нутгаа хамгаалахад оролцох нь хүн бүрт хэрэгтэй болохыг, мөн биологийн төрөл зүйлийн бүрэлдэхүүн хэсэг болох бөхөнгийн ач холбогдолыг уг үйл ажиллагаанд онцгойлон үзүүлсэн. Сургуулийн хүүхдүүд бөхөн хамгаалал, экологийн талаар ялгаатай концепт тоглож, мөн урлаг, гар урлалын тэмцээн зохион байгуулж байв. Шагналууд тэмцээний ялагч болон бүтээлч багш нарын аль алинд нь очиж байв. Сургууль бүр маргагашгүй хөтөлбөр зохион байгуулсаны нэг нь Жаслик тосгоны 54-р сургуулийн хүүхдүүд болон эцэг эхчүүдийн дунд зохион байгуулсан спортын арга хэмжээ байв. Энэ нь насанд хүрэгчид өөрсдийн хүүхдүүдтэйгээ анх удаа хамтран оролцсон тэмцээн юм. Каракалпака тосгоны 26-р сургуулийн хүүхдүүд Казах, Орос, Англи хэлээр байгаль дэлхийн тухай шүлэг уншиж, дуу дуулан хэлний чадвараа харуулсан. Бас нэгэн оргил хэсэг нь ялгаатай бүжгийн үзүүлбэр байв. Каракалпак тосгоны 56-р сургуулийн хүүхдүүд бөхөнтэй холбоотой шидэт үлгэр, домогт

үндэслэн утсан хүүхэлдэйн жүжиг тоглосон бөгөөд тэдгээрийн олонхийг өөрсдөө зохиосон байв. Үзэгчид Каракалпакын хоёр сургуулийн хийсэн ажилд сэтгэл хангалуун байсан. Хүүхдүүд бөхөнгийн экологи болон бусад хээр талын амьтдын тухай маш сайн мэдлэгийг илэрхийлсэн.

## Оросын Холбооны Улс

Олон улсын бөхөн хамгаалах өдрийн хэсэг болгон Халимагийн БНУ-ын Зэрлэг амьтдыг хамгаалах төв тэжээвэр бөхөнг харах боломжийг олгож, Халимаг болон бусад газар дахь бөхөн хамгааллын түүх, яриа, кино зэрэг үзүүлбэртэй өвөрмөц аяллыг хүүхдүүдийн дунд зохион байгуулсан. Хүүхдүүд спортын тэмцээн, үзүүлбэрт сэтгэл хангалуун байв. Яшкул, Черноземелский бүсийн сургуулиудаас нийтдээ 250 хүүхэд оролцсон.



Зүрэгийн К.Сурээж

Сурагчид бусад улсын бөхөнгийн найзуудыг хайхын тулд ил захидал бичиж байна.

Дэлгэрэнгүйг Ольга Климанова, [olga.klimanova@acbk.kz](mailto:olga.klimanova@acbk.kz); Елана Быкова, [esipov@xnet.uz](mailto:esipov@xnet.uz) болон Юрий Арылов нартай [kalmsaiga@mail.ru](mailto:kalmsaiga@mail.ru) холбогдоож авна уу.



Зүрэгийн А.Есипов

# СҮҮЛИЙН ҮЕИЙН МЭДЭЭ

## Казахстаны бөхөн хамгаалах эн тэргүүний ажлуудыг эхлүүлэх уулзалт

Кристина Roettger, UNEP/ЗАНЗХК-ийн нарийн бичгийн дарга нарын газар , [CRoettger@cms.int](mailto:CRoettger@cms.int)

Казахстаны Хөдөө аж ахуйн яамны ой, ангийн хороо, UNEP/Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах конвенцийн нарийн бичгийн дарга нарын газар Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах конвенцийн бөхөн хамгаалах харилцан ойлгоцлын санамж бичгийн техникийн зохицуулалтыг бий болгох, Казахстаны бөхөн хамгааллын эн тэргүүний үйл ажиллагааг хэлэлцэн тохирох зорилгоор Астана хотод 2-р сарын 17-18-нд хурлыг зохион байгуулсан.

Уулзалтанд Казахстан дахь зэрлэг амьтдын менежментийн мэргэжлийн байгууллагын төлөөлөл, Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлийг хамгаалах конвенци, бусад хамааралтай төрийн бус байгууллагууд хүрэлцэн ирж бөхөнгийн харилцан ойлгоцлын санамж бичгийн хэрэгжилт, түүнчлэн Бухара бүгүн хамгааллын статусыг хэлэлцсэн. UNEP/Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах конвенцийн нарийн бичгийн дарга нарын газар нь харилцан ойлгоцлын санамж бичигт тусгагдсан олон улсын дунд хугацааны ажлын хөтөлбөрийн (ОУДХАХ) хүрээнд бөхөн хамгаалах зайлшгүй шаардлагатай үйл ажиллагааг хурдастахын тулд техникийн дэмжлэг үзүүлэх гэрээг Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг (КБТЗХН), Бөхөн хамгаалах нийгэмлэг (БХН)-тэй байгуулсан.

Оролцогч талууд бөхөнгийн үхэл хорогдлын судалгааны зохицуулалт, цаашид их тоогоор хороддох үзэгдлээс сэргийлэх яаралтай арга хэмжээ зэрэг Казахстанд

нүүрлэж буй эн тэргүүний асуудлыг хэлэлцсэн. Хуулийн хэрэгжилт нь бас нэгэн эн тэргүүний асуудал байв. Уг зүйлийн орон нутгийн иргэдэд үзүүлж буй соёлын болон эдийн засгийн үнэ цэнийн асуудлыг тэдгээрийн тал хээрийн экосистем дэхь үндсэн үүрэгтэй холбон тодруулах, мэдээллийн урсгалыг сайжруулах явдал нь харилцан ойлголцлын санамж бичгийн техникийн зохицуулагчийн хувьд КБТЗХН, БХН-ийн гол зорилго юм. Хэдийгээр бөхөнтэй холбоотой мэдээллийн гол төв байхаар үсгэгдэх бөхөнгийн нөөцийн төвийн шинэ вэб хуудас байх боловч “Бөхөнгийн мэдээ” нь ЗАНЗХК-д тусгагдсан бөхөнгийн гэрээний хэрэгжилтэнд гарсан ахиц, төслийн үр дүнг үргэлжлүүлэн мэдээлсээр байх болно. Бөхөн хамгаалах төслийн онлайн мэдээллийн төв нь ОУДХАХ-г хэрэгжүүлэхэд чиглэсэн ахиц, дэвшлийг нийтлэх болно.

Хуралтай холбоотой тайлан, зөвлөмж зэрэг дэлгэрэнгүй мэдээлэл

[http://www.cms.int/species/saiga/other\\_saiga\\_meetings.html](http://www.cms.int/species/saiga/other_saiga_meetings.html)-д, ОУДХАХ (2011-2015)-ийг [http://www.cms.int/species/saiga/2ndMtg\\_Mongolia/Mtg\\_Rpt/Annex\\_5\\_MTIWP\\_2011\\_2015\\_E.pdf](http://www.cms.int/species/saiga/2ndMtg_Mongolia/Mtg_Rpt/Annex_5_MTIWP_2011_2015_E.pdf) татаж авах боломжтой.



Астанагийн хуралд оролцогчид

Зүргүй С.Зүтгер

## Баруун Казахстаны бөхөнгийн хорогдол

Бакытбек Дүйсекеев, Казахстаны Хөдөө аж ахуйн яамны Ой ангийн хороо, [cites@minagri.kz](mailto:cites@minagri.kz)

Баруун Казахстаны Занибекский мужийн Борсинский бүсийн Ой ангийн менежментийн хэлтсийн дарга уг бүс нутагт бөхөн их тоогоор үхсэн талаар 2011 оны 5 сарын 27-нд мэдээлсэн. Уг газар нь тус бүсийн Айдарли нутаг юм. 5-10 км нутагт 441 бөхөн үүнээс 354 эм, 77 янзага үхсэн байсныг олжээ. Холбогдох судалгааны хүрээлэнгүйд үхсэн зээр, хөрс, ус, ургамлаас эмгэг

судлалын дээжийг авсан. Шинжилгээний урьдчилсан дүнгээр бөхөнгүүд нь өнгөрсөн жилийнхтэй адил пастероллезоор (*Pasteurella multocida*) үхсэн болохыг тогтоожээ (Бөхөнгийн мэдээ №11-д нийтлэгдсэн өгүүллийг хар).

Биологийн төрөл зүйлийн хороо 2010, 2011 онд болсон бөхөн их тоогоор үхсэний шалтгааныг лабораторийн шинжилгээний үр дүнгээр судлах, түүнчлэн

тэдгээр тохиолдлын тухай дүгнэлт бичих, цаашид ижил төрлийн нөхцөл байдлаас сэргийлэх зөвлөмж боловсруулах олон улсын болон үндэсний шинжээчдийг хайж байна.

Тэд Казахын Боловсрол, ШУ-ны яамны шинжлэх ухааны хорооны Биологийн аюулгүй байдлын хүрээлэнтэй хамтран “Бөхөнгийн өвчинг илүү үр дүнтэй оношлох, урьдчилан сэргийлэх арга замыг бий болгох, экологийн болон тахлын мониторинг” нэртэй эрдэм шинжилгээ, судалгааны төслийг эхлүүлсэн.

Бүс нутгийн байгаль орчны байцаагч, Охотзоопром хамтран Уралын бөхөнгийн популяцийн төлөв байдалд мониторинг хийсэн бөгөөд популяци тогтвортой байгааг мэдээлсэн. 2011 оны 5-р сарын 30-наас эхлэн бөхөн уксэн тухай мэдээлэгүй байна.



Уралын популяцийн пастероллезаар хорогдсон бөхөн  
2010 оны 5 сар

## Казахстанд 2011 онд хийгдсэн бөхөнгийн агаарын тооллогын үр дүн

Юрий Грачев, Казахстаны Амьтан судлалын хурээлэн, [teriologi@mail.ru](mailto:teriologi@mail.ru)

Казахстаны бөхөнгийн агаарын тооллого 2011 оны 4 сарын 7-ноос 27-ны хооронд болсон. Казахын Боловсрол, ШУ-ны яамны Амьтан судлалын хүрээлэн, Казахын ХАА-н яамны ой ангийн менежментийн хороо, Охотзоопром, Ой ангийн менежментийн хэлтсийн бус нутгийн байгаль хамгаалах байцаагчид, Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэгээс хүмүүс оролцсон. Өнгөрсөн жилийнхтэй харьцуулахад тооллогын арга зүйд өөрчлөлтийг хийсэн. Тооллогын зурvasын өргөн 2 км байсныг 1,2 км (нэг талдаа 600 м) болгон багасгасан бөгөөд онгоцны далавчин дээрх хүчдэлийн угсыг тэмдэглэгээгээр (урт нарийн шон) өөрчлөн тогтоосон. Онгоц 120 м-ийн өндөрт нисэж байв. Томоохон сургийг илүү нарийвчлалтай тоолохын тулд 600 м тооллогын зурvasыг чиглүүлэн цонхны урд талд фото камераудыг суурилуулсан байв. Арга зүйг харьцуулахын тулд тоо



Бетпакдалагийн популяцийн судалгааны багийн гишүүд, Торгай хот, 2011 оны 4 сар  
толгойг 2 км-ийн өргөнтэй зурваст өмнөх арга зүйг ашиглан давхар тоолсон. Энэ нь 1,2 км өргөнтэй зурваст тоолоход популяциас хамаарч ойролцоогоор 1300-1800 бодгалийн хооронд тоог өсгөж байв. Ийнхүү үнэлэгдсэн популяцийн хэмжээг өссөн нь өмнө ашиглаж

байсан өргөн зурваст жижиг сүргүүдийг илрүүлэх боломж хомс байсантай холбоотой юм. Уг тооллогоор Казахстаны бөхөнгийн нийт тоо 102000 (2010 онд 85500 байсантай харьцуулахад) үүнээс Бетпак-далагийн популяци 78000, Устюртад 6100, Уралд 17900 толгой бөхөн байгааг тогтоосон. Өнгөрсөн жилийнхтэй харьцуулахад Бетпакдалагийн популяцийн үнэлгээ өсөж гарсан бол Устюртын популяци хэвийн хэмжээнд, харин Уралын популяци буурсан байна.



Агаарын тооллогын явцад авсан бөхөнгийн сүргийн зураг

# Дэлхий дээрх нэн ховор зүйлийг аврах боломж

Жессика Холдкрофт, Олон улсын шинжлэх ухаан, аялалын үзэсгэлэн, [holdcroft@sciencenorth.ca](mailto:holdcroft@sciencenorth.ca)


Зэрлэг амьтдыг аврах боломж буюу жинхэнэ амьтад, эдгээр амьтдыг амьд байлгахад туслахын тулдoeffский амьдралаа зориулж байгаа хүмүүсийн тухай үзэсгэлэн юм. Энэ үзэсгэлэнг Канадын Онтарио мужийн Судбури хотын шинжлэх ухааны төвд Science North бий болгосон. Science North-д 10 сарын турш үзүүлсний дараа уг үзэсгэлэн Канад, АНУ-ын шинжлэх ухааны төв, музейгээр аялах болно.



Зүргүүз Science North

## Судбури хотын Science North дахь зэрлэг амьтдын үзэсгэлэнгийн орох хаалга

Зэрлэг амьтдыг аврах боломж үзэсгэлэнгийн нэг нь дэлхий дээрх ховордож байгаа, устаж буй 30 гаруй зүйлүүдийн фото зураг бүхий 4 футын диаметр бүхий эргэлдэж буй дэлхийн бөмбөрцөг юм. Аялагчид мэдрэгчтэй компьютер ашиглан эдгээр зүйлүүдийн тухай илүү их мэдээллийг авдаг. Тэд амьтан тус бүрийн тухай сонирхолтой баримтууд, яагаад ховордсон, юу хийгдэж байгаа зэрэг мэдээллийг фото зураг, видео, текст хэлбэрээр авч болно. Уг үзэсгэлэнгийн онцлог үзмэр нь Хойд Америкийн үзэгчид хүлээн зөвшөөрч буй бөхөн бөгөөд Европийн хээрийн устаж буй гөрөөсний тухай эндээс мэдэж байна. Үзэгчид Халимагийн зэрлэг амьтан хамгаалах төвийн тухай уншиж, тус төвөөс гаргасан зургийг сонирхж болно. Зэрлэг амьтдыг аврах боломж үзэсгэлэнгээр орсон хүмүүс бөхөнг үржүүлэх, судлах, мониторинг судалгааг хийх, энэхүү цорын ганц зүйлийг хамгаалын ач холбогдолтыг олон нийтдэд түгээн дэлгэрүүлэх талаар Халимагийн зэрлэг амьтан хамгаалах төвд хийгдэж буй чухал ач холбогдолтой ажлуудын тухай мэдэж авч байна.



Зүргүүз Science North

## Дэлхийн бөмбөрцөгт дүрслэгдсэн амьтад

Илүү дэлгэрэнгүй мэдээллийг Kirsti Kivinen-Newman-ий [kivinen@sciencenorth.ca](mailto:kivinen@sciencenorth.ca) хаягаар авна уу.

A screenshot of a website titled 'Species Recovery Around the World'. The page features a green header with the title and language links 'Français'. Below the header, there's a section titled 'What's being done' with a sub-section about saiga antelope conservation in Kalmykia. It includes a photo of a saiga antelope, a map of its range, and a conservation status table. There are also three smaller photos: one of a saiga in captivity, one of a saiga being released into the wild, and another of a saiga in its natural habitat. At the bottom, there are navigation links for 'Habitat', 'Did you know?', 'Why are they threatened?', and 'What's being done?'.

Халимагийн Зэрлэг амьтан хамгаалах төвийн мэдээллийн хуудас

## Хүн бүрээр бөхөнг хамгаалуулья!

Данара Зарболова, КБТЗХН, [danara.zharbolova@acbk.kz](mailto:danara.zharbolova@acbk.kz)

Бөхөн болон бусад хээр талд амьдрягч амьтдыг хамгаалахын ашиг тусын тухай хүмүүст хэлэхээр халуун хүйтний алинд ч хэдэн зуун километрийг туулах нь Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэгийн мониторинг сурталчилгааны багийн үүрэг юм. Өнгөрсөн 2 жилийн туршид тэд Германы Хүрээлэн буй орчны хамгаалал, цөмийн аюулгүй байдлын улсын яамны Стамп сангийн (Stamp Fund) дэмжлэгтэйгээр Бетпакдалагийн бөхөнгийн популяцийн тархац нутгийн ойролцоо тосгодуудад олон нийтийн боловсрол,

сурталчилгааны ажлыг гүйцэтгэж байна. Тосгон бүрт КБТЗХН-ийн баг сургуулийн сурагчид, орон нутгийн удирдлага, олон нийттэй уулзалт зохион байгуулж байна. Тэд үзүүлэн, баримтат кино, радиогийн төрөл бүрийн мэдээллийн материалыг бэлтгэж байна. Мөн тэд өсвөр үеийн сургуулийн хүүхдэд мэдээллийг мэдлэг болгон илүү хүргээжтэй, сонирхолтой хэлбэрээр хүргэхийн тулд тоглоом, үйл ажиллагааг ашигладаг. Өнгөрсөн 2 жилийн туршид энэ тесэл нь (Германы Хүрээлэн буй орчны хамгааллын яамнаас санхүүжиж байгаа) зарим тохиолдолд хамтарсан

хамгаалал, хулгайн ангийн эсрэг үйл ажиллагаанаас илүүтэйгээр олон нийтийн сурталчилгааны ажил үргэлжлэн явагдах ёстойг харуулсан нь чухал ач холбогдолтой зүйл болсон юм.

Төслийн хугацаанд тус баг нь Караганда, Костанай, Кызыл-Орда болон Баруун Казахстаны бүсэд 50 гаруй суурин газарт айлчилж, нийт 6000 хүний хамарсан харилцан адилгүй бүлэгтэй 110 гаруй уулзалт зохион байгуулсан байна. Эдгээр уулзалтууд зөвхөн тэднийг сургах биш, орон нутгийн хүмүүстэй харилцааг дээшлүүлэхд чиглэсэн байсан. Тосгоны оршин суугчид бөхөн хамгааллын шууд болон шууд бус асуудлыг хэлэлцэхэд чөлөөтэй оролцож байна. Эдгээр харилцаанд гол болгон илүү их онцолж байсан асуудал нь хулгайн ангийн цаад шалтгаан, амьдрах орчны өөрчлөлт, бөхөнгийн амьдралын мөчлөг, биологийн төрөл зүйл болон экосистемийн хамгаалалд орон нутгийн иргэдийн үүрэг оролцоо, мөн агнуурын менежертэй хамтран ажиллах зэрэг асуудал хамрагдаж байв.

Энэ төслийн явцад цуглуулсан туршлага, боловсруулсан материал нь 2011 оны 3 сарын 12-15 ны хооронд Ой ангийн менежментийн хорооноос явуулсан том хэмжээний олон нийтийн сурталчилгааны кампанит ажилд ашиглагдсан. Энэ кампанит ажил “Хүн бүрээр бөхөнг хамгаалуулъя” уриатай байсан. Хоёр баг бөхөнгийн тархац нутаг дахь тосгодуудад КБТЗХН-ийн гишүүд, хэвлэл мэдээлэл, хууль хэрэгжүүлэх газрын гишүүдийг оролцуулсан үйл ажиллагааг зохион байгуулсан. Хамгаалах багаж төхөөрөмжөөр тоноглогдсон тэдний хоёр машин бөхөнгийн нүүдлийн замын байршил эсвэл төрөх газар төвлөрсөн Караганда, Костанай, Кызылорда бус нутгийн тосгон, хотуудын хооронд давхиж байв. Казахстаны бөхөн хамгаалалд оролцож буй бүх байгууллагууд орон нутгийн хүмүүст түшиглэн хамгааллын үйл ажиллагааг хамтран хийх сонирхолтой нь тодорхой юм.

## Хэвлэлийн мэдээ

### Хятадын бөхөнгийн тоо өслөө

Хятадын баруун хойд хэсгийн Гансу мужийн Гансу ховордсон амьтдын судалгааны төвд байгаа тэжээвэр бөхөнгүүд 2011 оны 4 сарын 26-наас төллөж эхлэн 31 янзага төрөн уг төвийн бөхөнгийн нийт тоог 105-д хүргэлээ. Сүүлийн 10 жилд Хятадад бөхөн зэрлэгээр олдоогүй учраас байгаль дээр устаж алга болсонд тооцогдож байв. Гансу ховордсон амьтдын судалгааны төв нь 1998 оноос эхлэн 12 толгой бөхөнг авчирсан бөгөөд уг сүрэг нь эдгээр бодгалиас гаралтай юм. Уг төв нь зэрлэг байгальд тэдгээрийг нөхөн сэргээхийн тулд илүү олон бөхөнг үргүүлэхээр зүтгэж байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг  
<http://english.peopledaily.com.cn/90001/90776/90882/7395693.html> хаягаар авна уу.

### Казахстаны хууль хэрэгжүүлэх байгууллагууд хууль бус агнуурыг бууруулах үйл ажиллагаанд нэгдлээ

Дотоод хэргийн яам, ХАА-н яам, олон улсын байгаль хамгаалах байгууллага, орон нутгийн эрх баригчид, хууль сахиулагч нарын төлөөлөл оролцсон бус нутгийн уулзалт 2011 оны 5 сарын 21-нд Костанай мужийн прокурорын газарт болсон. Энэ уулзалтаар бөхөн хамгааллын асуудал, хууль бус агнуурыг хянах арга хэмжээг хэлэлцсэн. Хууль бус агнуур бол бөхөнгийн популяцийг нөхөн сэргээхэд хамгийн том саад тогторын нэг болохыг тэмдэглэсэн байна. Эрэгчинг сонгон агнах явдалд илүү их санаа зовж байна. Бетпакдала, Уралын популяцији дахь эр бөхөнгийн хувь 12% байсан бол Устюргад ердөө 6 % байна.

Уг уулзалтыг удирдсан ерөнхий прокурор Иоган Меркел Дотоод хэргийн яаманд бусад байгаль хамгаалах газартай хамтран хууль бус анг илрүүлэх, бууруулах, илрүүлсэн гэмт хэргийн тоог нэмэгдүүлэх, энэ хэлбэрийн гэмт хэргийн хяналт шалгалтыг чанарыг нэмэгдүүлэхэд зайлшгүй шаардлагатай арга хэмжээг авахыг зөвлөсөн.

ХАА-н яам Ой ангийн менежментийн хэлтэс, “Охотзоопром”-ын бус нутгийн байцаагч нарын үр бүтээмжийг дээшлүүлэх хэрэгтэй онцолсон. Олон нийтийн прокурорын газар байгаль орчныг хамгаалах хуулийн хэрэгжилтийг сайжруулах, хууль хэрэгжүүлэх газруудын зохицуулалтыг дээшлүүлэх талаар үүрэг авсан. Энэ уулзалтаар мөн Костанай мужийн Алтын дала БНГ-ыг улсын тусгай хамгаалалтанд яаралтай авах талаар хэлэлцсэн.

Илүү дэлгэрэнгүйг доорхи хаягаар авна уу.  
<http://inform.kz/rus/article/2381977>.

Казахстаны ХАА-н яамны харьяа Ой ангийн хороо, Дотоод хэргийн яамны Цагдаагийн гүйцэтгэх хороотой хамтран бөхөнгийн хууль бус агнуур, тэдний мах, эзвэр худалдахтай холбоотой хуулийг сайжруулах, нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг эхэлсэн. Одоо мөрдөгдөж байгаа хуулийн дагуу хулгайн анчид торгууль төлдөг байсан. Уг саналд хулгайн анд ашигласан тоног төхөөрөмж тухайлбал машин зэргийг эд мөрийн баримтад тооцон хураах асуудлыг хамруулсан. Ой ангийн менежментийн хорооны дарга Ерлан Нысанбаевын тооцоолсоор энэ алхам нь зохион байгуулалттай агнуурын бүлгийг багасгахад хангалттай нөлөө үзүүлэх болно.

Илүү дэлгэрэнгүйг <http://vesti.kz/society/79547> авах боломжтой.



Худалдаачид бөхөн болон хирсний эврийг худалдаж авахад бэлэн байна.

Баруун Казахстаны олон нийтийн прокурорын газарт 2011 оны 5 сарын 04-нд бөхөнгийн төллөлтийн үед хууль бус агнуурыг илүү идэвхтэй хянахын тулд “Бекире-2011” нэртэй хууль сахиулах ажиллагааг эхлүүлэх талаар хэлтэс хоорондын уулзалт болсон. Уг уулзалтанд засаг захиргааны төлөөлөл, Охотзоопромын шинжээчид оролцсон. Хэлэлцүүлэг хууль бус агнуурыг бууруулах, илрүүлэх арга зүйг эргэн харах, хамтарсан ажиллагаанд түлхэц өгөх, бусад хамааралтай байгууллагуудаар ахиц, дэвшлийн талаарх тайлан гаргуулах зэрэг асуудлууд багтсан.

*Илүү дэлгэрэнгүйг  
<http://www.zakon.kz/kazakhstan/213154-prokuraturojizkoprovedeno.html> хаягаар авна уу.*

## **Хууль бус худалдаа, хулгайн ангийн тохиолдол**

Устюртын популяци

### 2011 оны 1 сар - Узбекстан

Жаслик тосгоны Дотоод хэргийн хэлтсийн офицерууд Арсеналд үйл ажиллагаа явуулж байх үедээ нутгийн оршин суугчдаас зөвшөөрөлгүй 2 буу хураасан. Эрүүгийн хуулийн 243-р бүлэгт заасан “Галт зэвсэг хууль бусаар эзэмших” үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэсэн. Шүүх яллагдагчид торгууль ноогдуулсан. Нутгийн оршин суугчид сайн дураараа зөвшөөрөлгүй 4 буу хураалгасан.

Байгаль хамгаалах улсын хорооны Госбиоконтрол хэлтсийн байцаагч, Жаслик дахь дотоод хэргийн хэлтсийн офицеруудын хамтын ажиллагааны үр дүнд бүртгэлгүй 8 мотоцикл хураасан.

### 2011 оны 6 сар - Казахстан

Дотоод хэргийн офицерууд Саратов-Ташкент чиглэлийн галт тэргэнд зорчиж явсан 33 настай эрэгтэйг Атырау өртөөн дээрээс саатуулсан. Уг эрэгтэй Узбекстани Самарканд мужаас 62 бөхөнгийн эвр тээвэрлэж явжээ.

*Дэлгэрэнгүйг: <http://news.gazeta.kz/art.asp?aid=342637>*

## **Бетпакдалагийн популяци**

### 2010 оны 12 сарын 26- 2011 оны 1 сарын 15

Дотоод хэргийн яам бусад харьяа байгууллагатай хамтран “Бөхөн” нэртэй ажиллагааг Астюбинск, Кызылорда, Костанай, Караганда мужид явуулсан. Уг ажиллагаа бөхөнгийн хууль бус агнуурыг бууруулах, илрүүлэхэд чиглэсэн бөгөөд 5 хулгайн анчныг саатуулан тэднээс бөхөнгийн гулуз мах, эвэр зэргийг хураасан байна. Түүнчлэн хүрээлэн орчны хууль, галт зэвсэг авч явах, тээвэрлэх тогтоомжтой холбоотой 45 зөрчлийг илрүүлсэн.

*Дэлгэрэнгүйг:  
<http://kt.kz/?lang=rus&uin=1133168098&chapter=1153531179>.*

### 2011 оны 1 сарын 18

Байгаль орчны цагдаа, Охотзоопромын байцаагч нар шинээр хөрөөдөж авсан 8 эвэр бүхий хулгайн анчдыг саатуулсан.

Казахстани БНУ-ын Эрүүгийн хуулийн 288-д заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн (Хууль бус агнуур). Дэлгэрэнгүйг доорх холбоос дээр дарж үзнэ ҮҮ: <http://inform.kz/rus/article/2341522>.

### 2011 оны 2 сар

Кызылорда хотын орон сууцны байшигийн хашаан доторхи гражаас байгаль орчны байцаагч бөхөнгийн 3 гулуз мах, арьсыг олон хурааж авсан байна. Гражын эзэн эмэгтэй хувьдаа ашиглах зорилгоор танихгүй хүнээс бөхөнгийн гулузыг худалдан авсанaa хүлээсэн байна. Түүнд Казахстани Эрүүгийн хуулийн 183-р бүлэгт заасан “Гэмт хэргийн шинжтэй эд хөрөнгө худалдах, худалдан авах” үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэсэн.

*Дэлгэрэнгүйг:  
<http://kt.kz/?lang=rus&uin=1138536468&chapter=1153533396>*

Охотзоопромын офицерууд Зезказган хотоос 30 км зайд 2 УАЗ машиныг шалгах үед хэд хэдэн төрлийн ангийн буу, б гулуз мах, 7 бөхөнгийн арьс хураасан. Ойролцоо газраас тэд уутанд хийсэн бөхөнгийн махны хэсэг, 4 толгой, 9 хөл, 3 хос шинэ эвэр олсон байна. Саатуулагдсан жолооч нар тэдгээр амьтдыг алаагч, харин Зездинка гол дагуугаас тэдгээрийг олсон гэж мэдүүлсэн байна. Мах, арьсанд хийгдсэн мал эмнэлгийн шинжилгээ, мөн тэдгээрийн буудаадаа галт зэвсэг ашигласан эсэхийг шалгахын тулд буунуудад баллистик шинжилгээ хийсэн. Дээрх шалтгалтын дүнгээс шалтгаалан шүүхийн шийдвэр гарах болно.

*Дэлгэрэнгүйг:  
<http://kt.kz/?lang=rus&uin=1138536468&chapter=1153532553>*

### 2011 оны 3 сарын 18

Иргыз дүүргийн Дотоод хэлтсийн ажилтнууд Иргиз-Торгайский БНГ-т машинтай явж байсан хулгайн анчдыг саатуулсан. Шалтгалтын явцад 1 бөхөнгийн гулуз мах, ангийн буу олсон бөгөөд тэдгээрийг хураасан. Казахстани БНУ-ын Эрүүгийн хуулийн 288-д заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн (Хууль бус агнуур). Сэжигтэнд амьдарч байгаа газраасаа явж болохгүй сануулсан.

*Дэлгэрэнгүй мэдээллийг:  
<http://inform.kz/rus/article/2363159>.*

### 2011 оны 5 сарын 5

Ой ангийн менежментийн хэлтсийн Костанай хэсгийн офицерууд 3 жийп машин ашиглан бөхөн хөөж байсан хулгайн анчдыг саатуулсан. Мөрдөн байцаалт хийгдэж байна. Мэдээлэгч нар 2010 онд Костанай дүүрэгт 225 бөхөн агнасан болохыг гэрчилсэн.

*Дэлгэрэнгүйг: <http://vesti.kz/society/84621> авна уу.*

## **Баруун хойд пре-Каспийн популяци**

### 2011 оны 4 сарын 23

Бөхөнгийн 2 гулуз мах тээвэрлэж явсан Яшкил аймгийн 49 настай оршин суугч А Астрахан аймагт саатуулагдсан.

Тэрээр хууль бусаар бөхөн агнан Астрахан хот руу тээвэрлэж явсанаа хүлээсэн. Тэр “Гэмт хэргийн шинжтэй эд зүйлийг хадгалсан” гэх үндэслэлээр их хэмжээний торгууль хүлээнэ.

Дэлгэрэнгүйг  
[http://www.elista.org/index.php?option=com\\_content&view=article&id=11290:2011-04-25-12-14-35&catid=1:latestnews&Itemid=2](http://www.elista.org/index.php?option=com_content&view=article&id=11290:2011-04-25-12-14-35&catid=1:latestnews&Itemid=2) хаягаар авна уу.

## Монгол

Өнгөрсөн 11 сард Говь Алтай аймаг, Баянуул сумын 1 бөхөн хулгайгаар агнасан хэрэгт ноогдуулсан 1,5 жилийн хорих ял, 4 сая төгрөгийн торгуулийн (ойролцоогоор 3200 ам доллар) ялыг давж заалдах шатны шүүх хэвээр баталлаа.

# ӨГҮҮЛЛҮҮД

## Халимагийн бөхөнгийн жил: Гол үр дүн ба цаашдын төлөвлөгөө

Владимар Н.Мирошченко

Халимагийн БНУ-ын Байгалийн нөөц, хүрээлэн буй орчны хамгаалал, Энергийн яам,  
[v.miroshchenko@rk08.ru](mailto:v.miroshchenko@rk08.ru)

Халимагийн БНУ-ын төрийн тэргүүний зарлигаар 2010 оныг Халимагийн бөхөнгийн жил болгосон. Халимагийн байгаль хамгаалагчдад тулгарч байгаа үндсэн асуудлын нэг нь Плейстоценийн амьтны аймгийн эртний төлөөлөгч болох бөхөнг хамгаалах явдал юм. Бөхөнгийн тоо 1997 онд 270000 бодгаль байсан бол сүүлийн жилүүдэд 14000-16000 мянган толгой болж бодитойгоор буурсан байна. Ангийн хяналтын улсын газрын бие төлөөлөгчид, Халимагийн БНУ-ийн Байгалийн нөөц, хүрээлэн буй орчны хамгаалал, Энергийн яамны (Байгаль орчны яам) мэргэжилтнүүдтэй хамтран 2009 хийгдсэн тооллогын үр дүн, шинжээчдийн дүгнэлтээр өнөөгийн популяци 8-10 мянган толгой байна.

Бөхөнгийн жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийг Казахстаны БНУ-ын засгийн газрын тушаалаар 2009 оны 12 сарын 15-нд баталсан. Уг хөтөлбөрийн зохицуулагчаар үндэсний байгууллага, судалгааны баг, боловсролын хүрээлэн, Халимагийн засгийн газрын бие төлөөлөгч сонгогдсон.

Биологийн төрөл зүйлийг хамгаалах үндэсний стратегид орсон үндсэн зорилгын нэг нь амьтны “in-situ” хамгаалал (байгаль дээр нь хамгаалах) явдал бөгөөд бөхөнг байгаль дээр нь хамгаалах явдлыг дэмжссэн энэ арга хэмжээнд ихээхэн анхаарч байв. Энэ зорилгоор Шелл газрийн тос, хийн үйлдвэрлэлийн компанийн санхүүжилтээр Байгаль орчны яамны харьяа бөхөн хамгаалах тусгай хэлтэс байгуулагдсан.

Байгаль орчны яамны мэргэжилтнүүд амьтан хамгаалах хууль эрх зүйн дагуу зөвшөөрлийг хянах, зөвлөх ажлыг улсын хэмжээнд хийж байв. 2010 оны турш ан агнуурын хуулинд тогтоогдсон 10 гаруй цоорхойг арилгахын тулд 63 уулзалт зохион байгуулжээ. ОХУ-ын Эрүүгийн хуулийн 258-р зүйлийн дагуу (Хууль бус агнуур) 7 хэрэгт эрүү үүсгэн, 19 бөхөнг хууль бусаар агнасан 3 хүний хэргийг шийдвэрлэсэн.



Зүрээлэл / Виноградовий

### Бөхөнгийн янзага

Бөхөн хамгаалах эдгээр үйл ажиллагааны туршид Байгаль орчны яамны ажилтнууд орон нутгийн иргэдийн дунд ажил хийсэн. Гэсэн хэдий ч улсын зүүн хэсэгт бөхөн амьдарч байгаа нутагт хууль бус агнуур өндөр тувшинд байсаар байна. Энэ нь голчлон эдийн засгийн тогтвортгүй байдал, ажилгүйдэл, амар хялбар аргаар ашиг олох гэсэн хүслийн улмаас болж байна. Нэмж хэлэхэд хяналт шалгалт, урьдчилан сэргийлэх, боловсролын ажил Нэгдсэн улсын хуулийн хэрэгжилт, байгаль орчны бүтцээ шалтгаалан төдий л хүчтэй хийгдэхгүй байна.

Улсын ангийн хяналтын байгууллага, Черные Земли улсын биосферийн нөөц газар, Халимагийн БНУ-ын зэрлэг амьтан хамгаалах төв, Халимагийн улсын их сургууль, Хуурай бус нутгийн судалгааны хүрээлэн зэрэг бөхөн хамгаалах, популяцийг нөхөн сэргээх асуудлыг сонирхож буй талуудын хоорондын хамтын ажиллагааг тогтвортжуулахад чиглэсэн албан газар дундын хороог байгуулсан.

Халимагын БНУ-ын Зэрлэг амьтан хамгаалах төвийн ажилчид бөхөнгийн биологи, зориудын нөхцөлд үржүүлэх аргачлалыг боловсруулах судалгааны ажил гүйцэтгэж байна. Тус төвийн ажилд санхүүжилт дутагдалтай байгаа боловч тухайн зориудын үржүүлгийн төв нь байгаль дээр устаж алга болж буй уг зүйлийн популяцийн генийн санг үүсгэх ёстой.

Бөхөнгийн жилийн туршид хийгдэж байгаа томоохон хэмжээний үйл ажиллагаа, кампанит ажил нь бөхөн хамгааллыг сайжруулахаар төлөвлөгдсөн. Халимагийн БНУ-ын Боловсрол, Соёл, ШУ-ны яам улсын хэмжээнд биологийн багш нарын семинар, өсвөрийн экологичдийн чуулган, инновацийн төслийн үзэсгэлэн, хүүхдийн урлагийн тэмцээн, “Бөхөнгийн дуу” наадмыг зохион байгуулсан.

Үлдсэн асуудал нь бөхөнгийн биологи, экологийн шинжлэх ухааны судалгааг эрчимжүүлэх хэрэгтэй. Үндэсний хэмжээнд Судалгааны байгууллагуудын оролцоог хангасан бөхөнгийн мониторинг, тооллогын бүтцийг төлөвлөн хэрэгжүүлэх нь чухал юм.

Байгууллагуудын хурал нь Бөхөнгийн жилийн оолт амжилтыг дүгнэн хэлэлцээд цаашид Казахстан, Узбекстан, Туркменистан зэрэг улсуудыг оролцуулан бөхөнгийн байгалийн амьдрах орчинд нь хамгаалах олон улсын гэрээг бий болгож батлах нь чухал болохыг дүгнэсэн. Нэмж хэлэхэд бөхөнгийн эврийн хууль бус экспортыг бууруулахын тулд гаалийн үйлчилгээг чангатгах, холбогдох хууль эрх зүйн актад засвар оруулах, бөхөнгийн хууль бусаар агнасан эрүүгийн хэргийг чангаар шийтгэх зэрэг саналыг Ардын их хурлаас (Khural) ОХУ-ын Үндэсний асSEMBLEYН Төрийн Думд оруулах хэрэгтэй.

Оросын бөхөнгийн популяцийн хамгаалал нь дан ганц экологийн асуудал төдийгүй улсын засаг захирагааны бүх түвшинд шийдвэрлэх ёстой нийгэм эдийн засгийн асуудал юм. Ингэвэл баруун хойд пре-Каспийн хялганат хээр дэхь энэхүү цорын ганц гөрөөсний томоохон сургийг бидний үр хойч маань харан баясах боломжтой.

## Баруун Монголын Их нууруудын хотгорын монгол бөхөн хамгаалал

Буянаа Чимэддорж

ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, [chimeddorj@wwf.mn](mailto:chimeddorj@wwf.mn)

Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар Баруун Монголын Алтай Саяны эко бүс нутагт хамрагдах Их нууруудын хотгорын бөхөн хамгаалах төслийг дэмжиж байгаа MAVA байгууллагад талархаж байна. Төслийн урт хугацааны зорилго нь Их нууруудын хотгорын монгол бөхөнгийн нехөн сэргээх, дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн үндсэн тархац нутгийн хэмжээг нэмэгдүүлэх байв. Уг зүйлийн тоо толгой ойролцоогоор 8000 толгой хүртэл нэмэгдсэнд, 2007-2010 оны хугацаанд хуулийн хэрэгжилт, бөхөн хамгаалах орон нутгийн дэмжлэг, бөхөн амьдрах орчныг мал сүргээс чөлөөлөх зэрэг үйл ажиллагаанд гол дэмжлэг үзүүлсэн санхүүжүүлэгч байгуулагын үр дүнтэй, чухал хамгааллын ажилд талархаж байна.

Бид нөхөрлөлд суурилсан сайн дурын байгаль хамгаалагчдын сүлжээ, бөхөнгийн тархац нутгийн хүрээнд ажиллах хулгайн антاي тэмцэх баг, бөхөнгийн популяцийн тоо толгойн бууралт зогсож, эргэн өсөж эхэлж байгааг дуулгахдаа таатай байна.

Бэлчээр, усны төлөөх гэрийн мал, бөхөнгийн хоорондох өрсөлдөөнийг багасгах зорилгоор байгаль орчинд ээлтэй бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэн бөхөнгийн амьдрах орчинд малчдын нөхөрлөлүүд байгуулагдлаа. Анхны малчдын бүлэг 2009 онд хаврын сүүл, зуны улиралд (бөхөн төллөх улирал) зэрлэг ан амьтдын төлөө бэлчээрийг чөлөөлөх явдлыг зөвшөөрсөн. Энэ арга хэмжээний үр дүнд уг газарт тэднийг намар эргэн ирэхэд маш сайн өвлийн бэлчээр байснаар 2009-2010 оны хатуу ширүүн өвлийг малын хорогдолгүй давлаа.

Хамгаалалт дээшилсэн, газар нутгийн менежмент зэргээс хамааран хар сүүлт, жижиг хөхтөн, хоол хүнсэнд хэрэглэдэг шувуу зэрэг цөөн хэдэн зүйлийн амьтдын популяцийн тоо толгой өсөж байна.

Шаргын говьд цагаан зээр эргэн ирсэн нь төслийн гайхалтай амжилтын нэг юм.

Уг төсөл нь хүрээлэн буй орчны боловсрол олгоход ихээхэн тусалсан. Өсвөрийн клуб, мэргэшсэн орон нутгийн багш нар, бөхөн хамгаалагчдын дэмжлэгтэйгээр төсөл хэрэгжиж байгаа нутагт үйл ажиллагаагаа явуулж байна. Сургууль, өсвөрийн клубынхны оролцоо нь малчдад хамгааллын тухай өргөн хүрээтэй мэдлэг олгоход тусалсан бөгөөд төсөлд үзүүлэх орон нутгийн дэмжлэг нэмэгдсэн.

“Агаарын тооллого, Монголын том хөхтөн амьтдын хамгааллын шинэ хандлага” нэртэй төслийн хүрээнд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга зүйн дагуу Монголд анх удаа бөхөнгийн популяцийн үнэлгээг амжилттай гаргалаа. Энэ агаарын тооллогын арга зүй, үр дүнг (40% магадлтай 8016 бодгаль) Монголын болон олон улсын бөхөн судлаачид хүлээн зөвшөөрлөө. Энэ үр дүнд суурилсан газрын судалгааны арга зүй нь цаашдын популяцийн мониторинг хийхэд зориулан боловсрогдох болно.

Эдгээр үр дүнгүүд нь уг төсөл бөхөнгийн популяцийг нехөн сэргээх, тогтвортжуулахад чухал нөлөө үзүүлснийг харуулна. Их нууруудын хотгорын бөхөнгийн популяцийн тогтвортой өсөлтийг хангах, түүнчлэн тархац нутгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор уг төсөл дахин 3 жил үргэлжлэх болно. Төслийн 2-р шатанд 1 шатанд эхэлсэн дараах үйл ажиллагааг үргэлжлүүлэх болно.

- Байгаль хамгаалагчид, төрийн тодорхой байгууллагын ажилчдын чадавхийг нэмэгдүүлэн, хулгайн ангийн эсрэг болон бусад хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих

- Бөхөнгийн төллөх нутагт байгаа малчдын бүлгүүдийн харилцааг өргөжүүлэн, бэхжүүлснээр гэрийн мал, зэрлэг ан амьтны төлөө байгаль орчинд ээлтэй бэлчээрийн менежментийг бий болгох
- Газар нутгийн тогтвортой менежментэд хандсан төслийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд өсвөр үеийнхэн болон хөдөөгийн иргэдэд зориулсан боловсрол, сурталчилгааны ажлыг дэмжих,
- Уг төслийн шинэ хандлага болох онцгой нөхцөлд зориулсан бэлчээрийг бий болгохын тулд бэлчээрийг мал сүргээс чөлөөлөх, бэлчээр нутгийн дарамтыг бууруулах ажил эн тэргүүнд тавигдсаар байх болно.

Төслийн 2-р үе шатанд Шарга болон Хүйсийн.govийн бөхөнгийн популяцийг 2013 он гэхэд 30%-иар өсгөхөөр төлөвлөж байна. Бөхөнгийн амьдрах орчныг нэмэгдүүлэх, сайжруулахад үзүүлж буй малчдын бүлгийн дэмжлэгтэйгээр, Монгол бөхөнгийн популяцийн бууралт зогссон амжилтаар энэ зорилго биелэгдэх болно. Төслийн 2-р үе шат Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын Ховд дахь салбараар дамжин хэрэгжих болно. Үндэсний түвшинд ДБХС-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, ШУА, Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг, орон нутгийн засаг захиргааны төлөөлөл зэрэг байгууллагаас бүрдсэн зөвлөх хэсгийг байгуулах болно. Энэ нь уг төслийг хэрэгжүүлэхэд улс төрийн дэмжлэг, зохицуулалт, үр нөлөөтэй менежментийг хангах болно.

## Тал хээрийн нөөц газрын бөхөн хамгаалагчдын ажлаар- сэтгэлд хоногшсон аялал

Доминик Таел&Конни Таел –Егентер  
Загас ан судалалын хэлтэс,Aargue, Swis CIC [dominik.thiel@ag.ch](mailto:dominik.thiel@ag.ch)

Тавдугаар сарын сүүлээр Астраханы баруун урд орших Оросын өмнөд хэсгийн Тал хээрийн нөөц газрын эцэс төгсгөлгүй тал хээрт зочиллоо. Төрөл бүрийн болжморын дуугаар дүүрсэн агаартай хялганат хээр нь далайн давалгаатай адил салхины аясаар долгиолон байв. Бидний дуран хойноос ээх хурц шар нарны туяатай хамт умраас өмнө зүг рүү тэнгэрийн хаяаг нэгжинэ. Тал хээрийн нөөц газрын захирал Анатолий Клуднев нам гүмийг эвдэн “Тэд энд байна” гэлээ. Үнэндээ хэдэн цайвар бараан амьтад тэнгэрийн хаяанд далайг зүсэх онгоц лугаа адил өвст талд хөдөлж байна. Тэднийг аргамжаар чирсэн адил бүгд нэг зүгт шогшиж байв. Бөхөнгүүд, бидний анхны зэрлэг бөхөнгүүд. Дараагийн хэдэн өдөр энэ эцэс төгсгөлгүй талд өнжсөн бид өдөр бүр бөхөн харж байв. Гэсэн хэдий ч хэвлэлд дурдагдсан шиг том сүргүүд ердөө хэдэн жилийн өмнөөс алга болжээ.

Тал хээрийн нөөц газарт 2010 оны 5 сард хийсэн бидний аялалын гол зорилго нь бөхөн хамгаалах төсөлд зочилж, байгаль дээр нь бөхөнг хамгаалах үүрэгтэй орон нутгийн иргэдтэй уулзаж, ярилцах байв. Бид хамгааллын асуудлууд, энэ гөрөөс, хүмүүсийн хоорондох харилцаа холбоо, хамгааллын үйл ажиллагааны үр дүн, байгаль хамгаалагчид хир сайн тоног төхөөрөмжөөр хангагдсан зэргийг мэдэхийг хүсэж байлаа.

Астрахан мужийн баруун өмнөд буланд Халимагийн ЕНУ-тай хил залгаа пре-Каспийн районд орших энэ нөөц газар нь 2000 онд байгуулагдсан 800 км<sup>2</sup> талбайтай юм. Хамгийн ойролцоо тосгон Лиман нь 80 км зйтай. Нутгийн бөхөнгийн популяци 1980 онд 380000 толгой байсан бол 2010 оны дундуур 12000-с бага болтлоо буурчээ. Судлаачид одоогийн байдлаар 8000 толгойгоос бага бөхөн амьдарч байна гэж үнэлжээ. Өнөө үед бөхөнд учирч буй аюул занал нь хууль бус агуулж юм. Гурван эрэгчин амьны эвэр нэг сарын цалинтай тэнцэнэ. Энэ нутагт ажилгүйдэл маш өндөр хувьтай,



Тал хээрийн нөөц газрын захирал Анатолий Клуднев бөхөнгийн жижиг сүргийг ажиглаж байна. 2010 оны 5 сар хувиараа ажилласгад олон байх бөгөөд сайн цалин, ажил төрөл зөвхөн хотод л олдоно. Иймд өндөр түвшинд байх хулгайн ан нь тосгоны залуучуудын хувьд цорын ганц итгэл найдвар болдгийг хараад гайхах зүйлгүй.

Анатолий Клуднев, түүний байгаль хамгаалагчид, орон нутгийнхантай хийсэн олон гайхалтай уулзалтууд нь байгаль дээр бөхөнг хамгаалах нь хэцүү болохыг харуулж, бидний нүдийг нээсэн юм. Усгүй, сүүдэрлэх модгүй, байшин барилгагүй хээрт амьдарч байгаа тэдний туршлага бидэнд Степной нөөц газрын асуудлыг ойлгоход тусалсан юм. Оросоор хөндлөн гулд аялсан олон тооны аялалын туршид бид Анатолий Клуднев захирлын удирдлаган доорх Степной нөөц газрын байгаль хамгаалагчид шиг сайн зохион байгуулалттай, өндөр ур чадвартай хүмүүстэй хэзээ ч уулзаж байсангүй. Клуднев Бөхөн хамгаалах нийгэмлэгийн жижиг төслийн хөтөлбөрөөс авсан мөнгөө өөрийн ажилдаа зориулж байгаа бөгөөд цаашид СIC (Зэрлэг ан амьтан хамгаалах олон улсын зөвлөл)-ийн Швейцарын гишүүдийн санхүүгийн дэмжлэгтэйгээр ажлаа үргэлжлүүлэх болно.

Хууль бус агнууртай тэмцэх тэдний хойшлуулашгүй ажлыг үргэлжлүүлэхэд Анатолий Клудневын багт хангалттай бензин, байгаль хамгаалагчдын цалинг хангах мөнгө хэрэгтэй. Тэдний өдөр тутмын ажилгүйгээр бөхөнгүүд тухайн нутгаас бүрэн устаж алга болох бөгөөд гайхамшигт тал нутаг өөрийн хамгийн өвөрмөц, үзэсгэлэнтэй амьдрагчаа алдах болно.

Бөхөн хамгааллын үйл ажиллагаа тосгоноос гадагш байгаль дээр хийгдэх ёстой. Цаашид Бөхөн хамгаалах нийгэмлэгийн жижиг төслийн тэтгэлэг шиг бодит санхүүгийн дэмжлэг хэрэгтэй байна. Бид Анатолий ба түүний байгаль хамгаалагчдад бидэнд тал нутгаа танилцуулсанд баярлахын ялдамд бөхөн, түүний хамгаалах төсөл амжилттай хэрэгжихийг хүсэж байна!




Тал хээрийн нөөц газрын бөхөн хамгаалагчид захирал Анатолий Клудневын хамт (баруун гар талаас 3 дахь нь)

## Баруун хойд пре-Каспийд 2011 онд хийгдсэн бөхөнгийн мониторинг судалгааны урьдчилсан үр дүн

Сергей В. Сидоров

Улсын ан агнуурын хяналтын үндэсний төв, [in.for\\_sidorov@list.ru](mailto:in.for_sidorov@list.ru)

Баруун хойд пре-Каспийн бөхөнгийн популяцийн статусыг үнэлэх үйл ажиллагааны хурал 2011 оны 4 сарын 21-нд болсон бөгөөд уг хуралд олон байгууллагууд (Оросын Байгаль орчны яам, Халимагийн Байгаль орчны яам, Үндэсний ан агнуурын хяналтын байгууллага (Центрохотконтрол) Черные Земли улсын биосферийн нөөц газар) харилцан санал солилцсон. Уг уулзалтыг ОХУ-ын Байгалийн нөөц, Экологийн яамны АН агнуурын зохицуулалт, хамгааллын хэлтсийн дарга ноён А.Е.Берсенев удирдсан. Энэ уулзалт Халимагийн Байгаль орчны яамны удирдлага дор (Ю.В.Каминов), Байгаль орчны яам ба Черные земли нөөц газрын (В.Л.Г.Дордзиев, Б.С.Убушаев) мэргэжлийн туслалцаа, АН агнуурын үндэсний төвийн (С.В.Сидоров) шинжлэх ухааны удирдлаган дор бөхөнгийн мониторинг хөтөлбөрийг эхлүүлэх, дэмжихэд чиглэгдсэн. Уг судалгааны үндсэн зорилго нь газрын болон агаарын судалгааг ашиглан популяцийн статусын тоон үнэлгээг өгөх, төрснөөс хойших эхний хэдэн өдөрт янзаганы мэнд үлдэлтийг үнэлэх явдал байв.



Газрын зураг.  
2011 оны бөхөнгийн төллөлтийн бөөгнөрлийн байршил  
(ногооноор тэмдэглэсэн)

Бөхөнгийн төллөх үеийн бөөгнөрөл 1980-аад оны сүүлээр янзагалах үедээ цугларч байсан газрын ойролцоо, 2009-2010 оныхтой бараг адил газарт буюу Елиста-Астраханы замын өмнөд хэсгийн хээр тал, Черные Земли нөөц газрын хойд хэсэгт ажиглагдсан.

2011 оны төллөсөн газар 2008 оны 5 сартай ойролцоо хэмжээтэй буюу бараг  $50 \text{ км}^2$  байсан (газрын зургаас хар). Их хэмжээгээр төллөх явдал 5-р сарын 7-10нд орсон их борооны дараа буюу 5 сарын 12нд эхэлж, 5 сарын 15-нд дууссан. Төллөлтийн хугацаа нь Улсын ан агууруын хяналтын газраас 2010 оны 12 сард бөхөнгийн популяцид хийгдсэн судалгаан дээр үндэслэн гаргасан (5 сарын 8-9) хугацаанаас онцын зөрөөгүй байв. Их хэмжээгээр төллөх үзэгдэл нь хүйсийн харьцаа нөхөн үржилд тохирсон болохыг харуулсан бидний мэдээлэл үнэн болохыг баталсан (орооны эхэн үед 10%-иас дээш, дунд үед 5%).

Төрөлтийн эрчим, төрсөөс хойш 3 өдрийн дараах янзаганы мэнд үлдэлтийг үнэлэх зорилготой 3 удаагийн судалгааг (5 сарын 12-16) 5 өдөр явганаар гүйцэтгэв. Энэ ажлыг улсын ан агууруын хяналтын төвийн ашиглаж байсан аргачлалын дагуу эмэгчний нягтрал өндөртэй нутгуудад гүйцэтгэсэн. Нийтдээ 100 км зайд 240 шинээр төрсөн бөхөнгийн янзага (амьд, үхсэн алин алиныг оролцуулан) байгааг тогтоосон. Янзаганы үхлийн эрчим 2009, 2010 онд тогтоогдож байснаас 2 дахин бага буюу 4,2% байсан. Шируүн бороог үл харгалзвал бөхөн төллөх үеийн цаг уурын нөхцөл харьцангуй сайн байсан: янзаганы мэнд үлдэлтийн томоохон шалтгааны нэг болох боломжтой байсан агаарын температур онцын өөрчлөлтгүй байсан.

Агаарын судалгааны баг анх удаа популяцийн үнэлгээнд нисгэгчгүй агаарын хөлөг туршиж үзсэн. Уг онгоцонд 363 м хүртэл өргөнтгэй, 40 м<sup>2</sup> талбайгаар 4000 зураг авах чадвартай Canon EOS-550 камерыг суурилуулсан байв. Агаарын зургийн хамгийн өндөрөөс авсан нь 600 м байсан бөгөөд гэрэл зургийн чанар сайн байсан.

Газраар явж нүдээр бүртгэх ажлыг 5 сарын 17-нд бодгалийн (төллөөгүй) тоог тоолох зорилгоор бөхөнгийн бөөгнөрлийн тойрог дагуу гүйцэтгэсэн.

Шинжээчдийн үнэлгээгээр нийтдээ 6000 бодгаль тоологдсон бөөгнөрлийн төв хэсэгт 4000-с илүү бие гүйцсэн бодгаль бүхий бөхөнгийн бөөгнөрөл ажиглагдсан ба тэдгээр нь судалгаа хийгээгүй газарт тохиолдсон. Бөхөнгийн бөөгнөрөлд ороогүй сүргүүд, сүргийн захаар байгаа ганц нэгээр явж байгаа амьтдыг оролцуулан тооцвол нийтдээ 7000 орчим бодгаль байсан. Энэ үнэлгээг ойролцоогоор гаргасан тул болгоомжтой хандах ёстой, гэвч энэ нь бөхөнгийн тоо толгойн хамгийн бага түвшин болохыг баталж байна.

Үүнээс узвэл баруун хойд пре-Каспийн бөхөнгийн популяцийн үлдэгдэл улам бүр багассаар байна.



**Нисгэгчгүй агаарын хөлгийг бэлдэж байна**

Уг газарт байгаа популяцийн экологийн шалгуур үзүүлэлтэнд ноцтой зүйл ажиглагдаагүй (нөхөн үржлийн эрчим, нас хүйсний бүтэц). 2011 онд их хэмжээгээр төллөсөн явдал нь орооны үед эрэгчингийн тоо хангалттай байсан боловч хүйсийн харьцаа хэвийн хэмжээнээс бага байсныг баталж байна.

Энэ нь популяци өнгөрсөн жил ихээхэн хорогдсон болохыг харуулна. Үхлийн эрчмийг багасгахын тулд бид баруун хойд пре-Каспийн чонын тоог бууруулах (ДЦГ дахь тоог хянах), хууль бус агууруын эсрэг үйл ажиллагааг сайжруулах, мөн одоо сайн ургасан байгаа ургамлан бүрхэвчийн улмаас 2011 оны зун гарч болох хээрийн түймрийн аюулыг багасгахыг зөвлөж байна.



**Бөхөнгийн агаарын зураг**

# Бетпакдалагийн бөхөнгийн популяцийн тооллогод агаарын судалгаа, хэт улаан тяяны зураглалыг ашиглах туршилт

Алберт Салемгареев

Казахстаны Биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг (КБТЗХН)

[albert.salemgariev@acbk.kz](mailto:albert.salemgariev@acbk.kz)

Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг, Охотзоопром, Казахстаны ой, ангийн менежментийн зөвлөлтэй хамтран бөхөнгийн тоо толгой, демографийн мэдээлийн үнэмшилийг дээшлүүлэх зорилгоор мэдээллийн боловсруулалт, агаарын судалгааны арга зүйг сайжруулах судалгааг дуусгахаар ажиллаж байна. Энэ ажлын сүүлээр ой ангийн хороо бөхөнгийн тооллогод хэт улаан тяяны зураглалыг ашиглах туршилтын ажлыг эхлүүлсэн. Энэ арга нь далайн хөхтөн амьтдын тоо толгой, тархацын үнэлгээнд сүүлийн 20 жилийн турш амжилттай хэрэглэгдэж байна (Бөхөнгийн мэдээ №8).


Казахстаны тал хээрийн экосистемийг хамгаалах НҮБХХ(Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр)/ДДБХС (Даян дэлхийн байгаль хамгаалах сан)-гийн төслийн хүрээнд 2011 оны 4 сард Бетпакдалагийн бөхөнгийн популяцийг тоолох үед FLIR-325 хэт улаан тяяны зураг авагчийг шалгах туршилтын нислэг үйлдсэн. АН-2 онгоцны бүхээгийг автоматчилагдсан мэдээ цуглуулах систем, фото зураг болон видео хийх багаж, хэт улаан тяяны зураг авагчаар (IR) тоноглосон. Уг ажлыг Оросын экологи, эволюцийн хүрээлэнгийн мэргэжилтнүүд, КБТЗХН-тэй хамтран гүйцэтгэсэн. Туршилтын 3 нислэгийг үйлдэж бөхөнгийн 15 сүргийг тодорхойлсон. Энэ үр дүн нь дараах зүйлийг харуулж байна.

- Зурган дээрх бөхөнгийн биеийн дулааны ялгаа харилцан адилгүй байна. Газрын гадарга наранд халаагүй өглөөгүр дулааны ялгаа 3-5° хүрч байсан ба IR зурганд амьтад хялбар танигдаж байсан. Газрын гадарга халаад эхлэхээр бөхөнг ялгахад хүндрэлтэй болсон. Бага үд буюу 12 цагийн үед IR зураглал үр дүнгүй байв (1-3-р зураг)
- IR зураг авагчийн мэдрэмтгийг байдал, орон зайн задрал нь 120 м-ийн өндөөс бөхөнг таних боломжийг олгож байна. Үүнээс өндөр бол үр ашиг нь буурах болно (4-5-р зураг).

Тэгхээр хэт улаан тяяны зураглал нь газрын гадарга наранд халаагүй, хур тунадасгүй, салхины хув 8м/сек-с бага, нислэгийн өндөр 120 м-с дотогш нөхцөлд тохиромжтой юм. Өвлийн улиралд хүйтэн гадаргуу болон бөхөнгийн биеийн дулааны ялгаа их байх учраас үр дүнтэй байж магадгүй юм (жишээлбэл мөсөн дээрх далайн хав шиг). Гэсэн хэдий ч үүнийг батлах шаардлагатай. Дээрх бүх хандлага нь хаврын улиралд IR зураглал тохиромжгүй болохыг харуулна.

АН-2 онгоц 100-200 м өндөрт нисэж байх үед авсан бөхөнгийн зураг маш үр дүнтэй байна (1-5-р зураг). Зургийн чанар нь эрэгчин, эмэгчинг ялган, сүрэг доторхи бодгалиудыг ялгах боломжийг олгож байна.

Видео зураг нь туслах чанартай байсан. Үүнийг хэрэглэх нь тухайн үед өрнөж буй үйл явдлыг: бөхөнгийн ер бусын зан авир, бөхөнд нөлөөлж хүчин зүйлүүдийг (тухайлбал хууль бус агнуур) тогтоох боломжийг олгож байв. Иймд Экологи, эволюцийн хүрээлэнгийн



Зураг 1-3.

Одрийн өөр цагт авсан бөхөнгийн сүргийн харьцуулсан зургууд (зургийн зүүн дээд өнцөгт цагийг тэмдэглэсэн байгаа). Нислэгийн өндөр 120 м.

мэргэжилтүүд агаарын зураглалыг дэмжих дүрслэлийн дараах аргыг зөвлөсөн.

- Хөдөлгөөнгүй суурилуулсан 3 ш Nikon 300 аппаратыг ашиглан зураг авах. Энэ нь нислэгийн өндөрөөс тооллогын зурвасын өргөнд 2 удаа тоолох боломжыг олгоно. Тооллогын зурвасын өргөнийг нарийн тогтоож (нислэгийн өндөрөөр) хянах хэрэгтэй. Амьтан илрүүлэх магадлал нь гэрэл зургийг томруулж харах боломж, бөхөн




Photo 4.

нислэгийн шугамнаас хир зэрэг алслагдсан байгаагаас хамаарна.

- Онгоцны 2 талаас нүдээр ажиглан нислэгийн шугамнаас бөхөн хүртэлх зайд хэмжих
- Онгоцны явж буй солбилцол, өндөр, дуу, фото болон нүдээр ажигласан мэдээлэл, түүнчлэн үйл явдлын цаг хугацааг нарийн тодорхойлох.



Photo 5.

Зураг 4-5.

**Харилцан адилгүй өндөрөөс авсан бөхөнгийн сүргийн зургийг харьцуулсан байдал  
(Зураг 4 – 180 м-ийн өндөр; Зураг 5 – 200 м-ийн өндөр)**

## Баскунчук нуурын бөхөн

Павел Амасов

Богдинско-Баскунчакский байгалийн нөөц газар, Орос, [pavelamosov@yandex.ru](mailto:pavelamosov@yandex.ru)

Баскунчук нуурын бөхөн нь Казахстаны Волга-Уралын популяцийн нэг хэсэг юм. Энэ нутаг нь Каспийн хагас цөлөрхөг бүсэд хамрагдах Волга мөрний зүүн гар талд Каспийн хотгорын хойд талд орших цэнгэг ус, гол горхитой гүвээрхэг тэгш тал юм. Уг газарт Богдинско-Баскучанский гэсэн төстэй нэртэй 2 дархан газар байгуулагдаж байна. Баруун Казахстанаас ирэх бөхөнгийн нүүдлийн зам Баскунчук нуурын зүүн эргээр дайрдаг. Өмнө нь энэ нутагт элбэг байдаг байсан бөхөн сүүлийн арван жилд үзэгдэх нь ховордож байна. Орон нутгийн анчны тооцоолсоор 1992 оны хавар нуурын зүүн эрэг дагуу 50000 орчим гөрөөс нүүдэллэн өнгөрсөн байна. Астраханы бүс нутгийн бөхөнгийн төллөлтийн бөөгнөрөл 1994 оны хавар энэ нутагт болсон. Сүүлийн жилүүдэд бөхөнгийн тоо толгой эрс багасаж зөвхөн жижиг сүргээр, ганц нэг амьтад Баскунчук нуурын ойролцоо тэмдэглэгдсэн. Жишээлбэл 2001 оны 7 сард 11, 10, 5, 6 бодгалтай сүрэг энэ нутагт харагдсан (зургийг хар). 2003 оны 5 сард 1, 4 сард 1, 7-р сард ул мөр тэмдэглэгдсэн. 2005, 2006 онд эдгээр дархан газрын алинд ч бөхөн ажиглагдаагүй бөгөөд 2007-2008 онд судлаачид дутагдалтай байсны улмаас ажиглалт хийгдээгүй байна. Сүүлийн жилүүдэд бөхөнгийн ажиглалт дахин хийгдэж эхэлсэн бөгөөд 2009 оны 7-р сард 2-3 амьтны ул мөр харсан.

Дархан газарт бөхөн ажиглалтыг 2010 оны 6-9 сард хийсэн байна. 6-р сард долоон бодгаль, 7-р сард олон тооны мөр, 8 сард тус бүр 8 бодгальтай 2 сүрэг, 9 сард олон тооны мөр, 2011 оны 1-2-р сард 1 бие гүйцсэн эрэгчин амьтан харжээ.

Тус нутгийн тусгай хамгаалалтын статусыг үл харгалзан эндхийн амьдрах орчныг хамгаалах асуудал тулгамдаж байна. Санхүүжилт дутагдалтайн улмаас дархан газрын байгаль хамгаалагчдын тоо буурч, бүх төрлийн тээврийн хэрэгсэл хомдолтой байна. Дархан газарт эргүүл хийхдээ байгаль хамгаалагчид морь ашигладаг.

Баскунчук нуурын эргэн тойрны газарт дархан газрыг байгуулахаас өмнө, дараагийн дархан газрыг байгуулахаас өмнө бөхөнг харгис хэрцгийгээр тогтмол агнадаг байсан (нисдэг тэрэгнээс агнах, мотоцикл ашиглан амьтныг хөөх гэх мэт). Сүүлийн жилүүдэд уг газарт бөхөн хулгайгаар агнасан мэдээлэл алга байна. Гэсэн хэдий ч орон нутгийн хүмүүсийн мэдээллээр 2010 оны намар дээд Баскунчак тосгонд хууль бусаар бөхөнгийн мах зарж байсан бөгөөд, Актубинскийн хотод жил бүр бөхөнгийн мах зардаг жишиг тогтсон байна. Актубинскт хэвлэгддэг “Проектор“ орон нутгийн хэвлэлд бөхөнгийн эвэр худалдах тухай зар нийтлэгджээ. Эдгээр баримтууд нь Астраханы бүс Казахстаны хөрш зэргэлдээ нутгийн аль алинд нь хууль бус худалдаа явагдаар байгааг баталж байна.


Энэ нөхцөл байдал нь өнөө үед Баскунчак нуурын эргэн тойрны нутгаас бүх бөхөнг алга болгож чадна. Өмнөх тоо толгойг нөхөн сэргээхэд цаг хугацаа, байгаль хамгааллын байгууллага, орон нутгийн хүмүүсийн Үлэмжхэн хичээл зүтгэл шаардагдана.

Энэ өдрийг хүртэл Актубинск хотын нийгэм эдийн засгийн нөхцөл байдал цогцоор судлагаагүй байсаар байна. Доод болон дээд Баскунчак тоснгоны эргэн тойрон амьдарч байгаа нутгийн иргэдийн олонх нь эдийн засгийн хямралын үед доод Баскунчак ажиллаж байсан “Russalt” компани, Волга төмөр зам, бусад газар ажиллаж байгаад цомхотголд орж ажлаас халагдсан байна. Энэ нь орон нутгийн хүмүүсийн хийж байгаа бөхөн зэрэг амьтдын хууль бус агуулж өөгшүүлсэн.

Одоо байгаль зэрлэг амьтад руу чиглэсэн хандлагыг анхааран дэмжих нь чухал юм. Энэ нь бөхөнгийн хамгааллыг дээшлүүлэх, орон нутгийн хүмүүсийн дунд зүйлийн хамгаалал, судалгааг дэмжих боловсролын хөтөлбөрийг бий болгохын тулд Астраханы бус нутгийн Ховордсон зүйлийн Улаан номонд бөхөнг хамруулах нь чухал юм.

Улсын дархан газар нь сургууль, орон нутгийн иргэдийн дунд сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулдаг боловч одоогоор энэ нь зөвхөн бус нутгийн хязгаарлагдмал тоотой хүмүүст хүрч байгаа учраас үр дүн багатай байна. Орос, Казахстаны дархан газруудыг холбосон бөхөнгийн хамгаалал, судалгааг хийхийн тулд хил дамнасан тусгай хамгаалалтай газар нутгийг байгуулах нь үр дүнтэй байх болно.

Энэ төсөл 2010 онд Бөхөн хамгаалах нийгэмлэгийн жижиг төслийн хөтөлбөрийн тэтгэлэгээр хийгдсэн.



**Газрын зураг.**  
Баскунчук нуурын ойролцоо 2001-2004 (1-6 цэг), 2010-2011  
(7-11 цэг) онд бөхөн тэмдэглэгдсэн цэг

## Бөхөн хамгаалах холбооны давуу, сүл талын дүн шинжилгээ

*Чери Роадес*



Санхүүжүүлэгчийн оруулсан мөнгийг зөв ашиглах, эерэг үр дүнг харуулахын тулд 1990 оноос эхлэн хамгааллын байгууллагуудын хэрэгцээ өссөн.

Тусlamжийн байгууллага зэрэг бусад салбарт ажиллаж байгаа олон буяны байгууллага хийж байгаа олон талын ажил, буяны ажил хийгдсэн газар нутаг дахь хүмүүсийн нөхцөл байдал сайжирсан эсэхийг санхүүжүүлэгчид харуулах зорилгоор өөрсдийн дэвшлийг хянах үнэлгээний хэрэгсэл ашиглаж эхэлсэн. Гэсэн хэдий ч хамгааллын байгууллагууд өнөөг хүртэл энэ хүрээний гадна хоцорч байна.

Хамгааллын байгууллагуудыг үнэлэх, хянахын ашиг тусыг харуулахын тулд Бөхөн хамгаалах нийгэмлэгийн SWOT (Давуу тал, Сул тал, Боломж, Аюул) анализыг хийсэн болно. SWOT анализ нь орон нутгийн болон олон улсад, мөн бөхөнгийн сурталчилгааны бизнес дээр

хамtran ажиллахад түгээмэл ашиглагддаг стратегийг төлөвлөх хэрэгсэл юм. Бөхөн хамгаалах нийгэмлэгт ажиллаж байгаа хүмүүсээр Бөхөн хамгаалах нийгэмлэгийн дотоод хүчин зүйл болох давуу тал, сүл тал, мөн гадаад хүчин зүйл боломж, аюул занал юу байгаа тухай судалгааг бөглүүлсэн. Үүний үр дүнд Бөхөн хамгаалах нийгэмлэгийн хамгийн том давуу тал нь шинжлэх ухан болон практикийн үр чадварын олон талт байдал, Бөхөнгийн мэдээ сэтгүүлээр мэдээлэл тарааж байгаа чадвар гэх мэт үйл ажиллагааны олон талыг хослуулахыг боддог хүчирхэг удирдах зөвлөл болон захирлуудын зөвлөл, мөн бөхөн хамгаалалд ажиллаж байгаа бусад байгууллагатай амжилттай хамtran ажиллах чадвар юм.

Бөхөн хамгаалах нийгэмлэгийн давуу тал болох эдгээр

амжилттай хамтын ажиллагаа нь төслийн санхүүжилтийг баталгаажуулах, хамгааллын төслийн хоёр талын ялгааг өсгөх, нэмэгдүүлэхэд тэдэнд туслаж байна. Бөхөн хамгаалах нийгэмлэгт санхүүгийн болон засаг захиргааны дэмжлэг дутагдалтай байдаг ба нэн тэргүүнд энэ хоёрыг шийдвэрлэх хэрэгтэй. Эдгээр сул талуудыг багасгах боломж нь ерөнхий захирадл туслах сайн дурын ажилчдыг ашиглах, бөхөн хамгаалах нийгэмлэгийн үйл ажиллагаанд доноруудыг оролцуулах, донор байгуулагын захиаг бий болгох, тэдгээрийн олон нийтэд танигдсан байдлыг нэмэгдүүлэх, илүү их хандивыг эрчимтэй татах зэрэг

## Бөхөнгийн баатрууд

### Хэрвээ чи өөрийн ажилдаа чин сэтгэлээсээ хандвал чиний амьдрал баяр хөөрөөр бялхах болно

**Редакторын тэмдэглэл:** Энэ удаагийн бөхөнгийн баатар бол Халимагийн БНУ-ын зэрлэг амьтан хамгаалах төвд 2003 оноос эхлэн амьтны аж ахуйн техникчээр ажиллаж байгаа Аслан Байделдинов юм. Редакторын баг түүнтэй утсаар ярьж ярилцлага авсан.

*Ped:* Аслан, чи яагаад бөхөн хамгаалах ажилд татагдсан бэ?

**Аслан:** Би хүүхэд байх үеэсээ л амьтанд хайртай байсан. Бид гэртээ нугас, галуу, үхэр, хонь тэжээдэг байсан. Бидний эцэг эх өдөр бүр амьтдыг хэрхэн асрахыг бидэнд сургаж байсан. Би бүх амьтдыг харцаар нь мэддэг, бүгд хоч нэртэй байсан. Би дунд сургуульд байхдаа анх удаа бөхөнг харсан. Тэнд маш их байсан бөгөөд манай сургуулийн хажуугаар гүйж яваа тэднийг байнга хардаг байв. Анх тэднийг харах үед надад тэдний гүйж яваа зам, хээр талд амьдрах мэдрэмж зэрэг энэ амьтантай холбоотой насан туршийн дурсамж бий болсон юм. Энэ бол надад бөхөн үржүүлгийн төвд ажиллах боломж ирэхэд тухайн үед огтхон ч эргэлзээгүйн шалтгаан юм. Би зөвхөн өөрийн дуртай ажлаа хийгээд зогсохгүй манай төвд тогтмол зочилдог Оросын болон гадаадын эрдэмтэн судлаачидтай уулзах завшаан тохиолддог учраас би аз жаргалтай байна гэж хэлэх ёстой. Жуулчид бидний ажилд үнэхээр талархаж байвал би баяр хөөр, сэтгэл хангалаун байдлыг мэдэрдэг. Учир нь би бас бөхөнгийн бяцхан “хоргодах байр”-ны амжилттай ажилд гар бие оролцож байна.

*Ped:* Чиний ажлын өдөр хэрхэн өнгөрдөг вэ?

**Аслан:** Миний ажилд сүртэй зүйл байхгүй. Миний ажлын өдөр цөөн хэдэн ажлаас бүрдэнэ. Өдрийн эхний хагас болон сүүлээр би бөхөнд анхаарал тавин тэднийг тэжээж, хашаа тойрон гадаалуулна. Тэгээд бид өвс хадаж, хашаа засаж сэлбэн, цэвэрлэдэг. Жуулчид үдээс хойш ирдэг учраас бидний бүх зүйл тэднийг ирэхээс өмнө бэлэн болсон байх учиртай. Ямар нэгэн ажил хийхгүй үед би хүмүүстэй тэжээвэр амьтдынхаа тухай ярилцан хашаагаар явган явах дуртай.

*Ped:* Бөхөнгийн тухай сонирхолтой түүхийг бидэнд ярьж өгөөч?

юм. Бөхөн хамгаалах нийгэмлэгийн ирээдүйд нөлөөлөх томоохон аюул занал нь байгууллагатай холбоотой асуудлаас илүү бөхөнд эрчимтэй нөлөөлж буй хууль бус агууру юм.

SWOT анализын судалгаа нь Бөхөн хамгаалах нийгэмлэг зэрэг хамгааллын байгууллагыг үнэлэх үр ашигтай, энгийн хэрэгсэл болох боломж их байгааг харууллаа. Энэ үнэлгээ нь Бөхөн хамгаалах нийгэмлэгийг “ховордож буй амьтан болох бөхөнг хамгаалах, ард иргэдийн хамгааллын үр нөлөөг нэмэгдүүлэх, хамгаалалд олон нийтийн боловсролыг хөгжүүлэх ” гэсэн ойрын 5 жилийн зорилго болон алсын харааг биелүүлэхэд туслах болно.



Зүрүүк Н.Арсланов

#### Өнчин янзага “шинэ ээж”-тэй боллоо-Аслан өөрийн бяцхан тэжээвэр амьтадгтай цуг

**Аслан:** Тэгэлгүй яхав. Хар-Булук тосгонд байсан түр хашаанаас анх энд бөхөн авчирч байсан эхний хэд хоногийг санаж байна. Тэр үед би бөхөнгүүдийг ажиглах, хооллох, хашааг цэвэрлэх гэж хашаа руу ордог

байв. Би амандаа дуу аялах үед бөхөнгүүд над руу ойртон ирж байсан. Удаан хугацааны дараа би миний дууг сонсож ессөн бөхөнгүүд дээр айлчилж очсон юм. Миний дууг сонсмогцоо хашааны булангас намайг чиглэн ирж, намайг тойрон алхаж байснаа тэжээлийн савыг үнэртэж байсан. Бөхөнгүүд миний аялдаг дуунд дасаж, ганцхан үүний танъж байна гэж би ойлгосон. Энэ бүхний дараа энэ бөхөнгүүд зэрлэг юм байна гэж хэлж чадах хүн байхгүй.

*Ред:* Та бөхөнгийн юунд нь илүү дуртай вэ?

*Аслан:* Би тэдний зан авирт илүү дуртай. Тэд эрх чөлөөтэй, сүр жавхлантай амьтад. Тэднээс ирж байгаа амьдралын хүч, энергийг тодорхойлох боломжгүй. Тэд ойлгож, мэдэрч чадна.

*Ред:* Танай ажилд тулгарч байгаа гол бэрхшээл юу вэ?

*Аслан:* Тэгэлгүй яах вэ? Бэрхшээлгүй ажил гэж үгүй. Хамгийн гол нь бид улсаас илүү их дэмжлэг (зөвхөн санхүү биш) авахыг хүсэж байна. Нөхцөл байдал сүйрлийн ирмэгт байна. Бөхөнгийн тоо толгой өдрөөс өдөрт буурсаар байна.

*Ред:* Танай ажилд байгаа саад тотгорыг хэрхэн давж гарах вэ?

*Аслан:* Бидний ажилд ямар саад бэрхшээл байгааг үл харгалзан хатуу, хариуцлагатай, зүрх сэтгэлээ зориулан ажиллаж чадвал түүнийг даван гарч чадна. Хүмүүс өөрийн хийж байгаа ажилдаа сэтгэл зүрхээ өгөх хэрэгтэй, тэгвэл амьдрал чинь баяр хөөрөөр бялхах болно.

*Ред:* Танай ажлын сайн тал нь юу вэ?

*Аслан:* Эхний зүйл бол эртний энэ гөрөөсийг хамгаалах бидний ажил маш сайхан ажил. Бид өөрсдийн хүүхдүүддээ тэднийг харуулж чадаж байгаадаа баяртай байдаг. Хамгийн сайн зүйл нь ном, зурган дээрээс үзэхээс илүүгээр өөрсдийн нүдээр харж байна. 2-рт: энд маш олон орноос ирсэн хүмүүстэй танилцах боломжтой, 3-рт: энэ нь Орос дахь бөхөн үргүүлгийн анхны төв учраас улиг болсон, залхуутай ажил биш.

*Ред:* Чамд бөхөн, өөрийн болон хамт олныхоо өмнөөс хүсэж явдаг зүйл байна уу

*Аслан:* Би байгаль дээр бөхөнгийн тоо толгойн бууралт зогсож, бөхөн хүмүүсийн үлгэр домогт хэзээ ч орохгүй гэдэгт маш их итгэдэг.

# Үргэлжилж буй төслийд

## БХН-ийн төслийдийн сүүлийн үеийн мэдээ

Е.Ж.Милнер-Гулланд, [e.j.milner-gulland@imperial.ac.uk](mailto:e.j.milner-gulland@imperial.ac.uk)



people's trust for endangered species |



صندوق محمد بن زايد  
للمحافظة على الكائنات الحية  
The Mohamed bin Zayed SPECIES CONSERVATION FUND

Бөхөн хамгаалах нийгэмлэг 2010 оны 11-р сараас 2011 оны 6 сар хүртэлх хугацаанд Узбекстан дахь бөхөн хамгаалал, пре-Каспийн бүсийн бөхөнгийн тархцын мониторинг судалгаа, Казахстаны Уралын бүс нутагт бөхөн хамгаалалд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх гэсэн 3 үндсэн судалгааны төсөл хэрэгжүүлж байна.

Узбекстаны төсөл нь Зэрлэг ан амьтан хамгаалах сүлжээ (WCN), Disney Cons for Change -ийн санхүүжилтээр удаан хугацаанд үргэлжлэн хийгдэж байгаа бөгөөд, 2011 оны 6 сараас Байгаль хамгаалах Витлей сан (WFN)-гаас нэмэлт дэмжлэг авсан байна. Уг төслийг Узбекстаны ШУА-ын Амьтан судалын хүрээлэнгийн Елена Бикова удирддаг.

Пре-Каспийн төслийг Мухаммед Бин Заведын сан (MBZ) сангийн нэмэлт дэмжлэгтэйгээр Руффорд сан санхүүжүүлдэг бөгөөд Степной нөөц газрын захирал Анатолий Клудневын оролцоотойгоор Халимагийн БНУ-ын Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн профессор Юрий Арылов удирддаг.

Уралын төслийг SOS зүйлүүдийн сан, Ховордсон амьтдыг хамгаалах хүмүүсийн сан (People's Trust for Endangered Animals) санхүүжүүлдэг бөгөөд Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэгийн Ольга Климанова удирддаг.

**Эдгээр 3 төсөл нь Лондонгийн эзэн хааны коллежтай хамтран ажилладаг бөгөөд зарим судалгааны ажлыг Лондонгийн эзэн хааны коллежийн магистр оюутнууд орон нутгийнхантай хамтран гүйцэтгэдэг. Эдгээр төслийн гарч байгаа үр дүнт Бөхөнгийн мэдээний дараагийн дугаарт мэдээлэх болно.**

# БӨХӨНГИЙН ШИНЭ ӨГҮҮЛЭЛ

**Howe, C., Medzhidov, R., Milner-Gulland, E.J.** (2011) Evaluating the relative effectiveness of alternative conservation interventions in influencing stated behavioural intentions: A case study of the saiga antelope in Kalmykia. *Environmental Conservation* **38**, 37-44

Бид пре-Каспийн бүсийн 8 тосгоны 250 гаруй хүнээс хамгаалалд оролцох тэдний уриалгахан зангийн илрэл болох бөхөн хамгаалалд зориулан хандивын мөнгө хир их байdag асуулга авсан. Эдгээр тосгодын хүмүүсийн зарим нь төслийн нийгмийн оролцооны хэсэг болдог бол, нөгөө хэсэг нь бөхөнгийн тусгай хамгаалалттай газар нутагт амьдардаг, бусад нь бөхөнгийн асуудлаар зөвхөн хэвлэлийн хүрээний мэдээллээс халиагүй зөргээр хамгаалалд оролцох байдал харилцан адилгүй байна. Хандивын мөнгөний хэмжээ хүмүүсийн хөндлөнгийн оролцооноос хамаарна. Ийм нийгмийн оролцоотой газарт ямар нэгэн зүйлээр хандив өргөх нь илүү дуртай байсан боловч хандивын хэмжээ маш бага байв. Хэвлэлийн мэдээллийн хүрээнээс халиагүй хүмүүс дунджаар хамгийн их хандив өгсөн бөгөөд хэдийгээр тусгай хамгаалалттай газарт амьдардаг боловч олон хүмүүс ямар нэгэн зүйл өгөөгүй ба хэрвээ тэд ямар нэг зүйлийг өгсөн бол маш бага байх байсан. Юу ч хандивлаагүй хүмүүс засгийн газар, олон улсын нийгэмлэг хамгаалалд зориулж мөнгө зарцуулах ёстой гэж хэлж байв. Бид боловсруулсан статистик загварчлалаар тосгонд уг хүмүүс хир удаан оршин суусан, нас, бэл бэнчин, бөхөнгийн талаарх мэдлэг зэрэг хандивт нөлөөлж байгаа бусад нөлөөг шалган үзсэн. Энэ нь хэвлэлийн сурталчилгааг нэмэгдүүлэх нь хамгаалалд оролцох хүмүүсийн оролцоог өөрчлөх ач холбогдолтой болохыг харуулсан.

**Singh, N., Milner-Gulland, E.J.** (2011) Monitoring ungulates in Central Asia: Current constraints and future potential. *Oryx* **45**, 38-49

Бид Төв Азийн тууртны мониторинг судалгаанд хэрэглэгдэж байгаа аргуудыг хянаадаа мониторинг судалгааны үр өгөөжийг дээшлүүлж байгаа практикийн болон онолын хандлагыг тодорхойлж, харилцан адилгүй шалгуурт үндэслэн мониторинг аргуудыг ангилж үзсэн ба ингэснээр судлаачид өөрсдийн сонирхож буй зүйлд тохиromжтой хамгийн сайн мониторинг судалгааг төлөвлөх боломж бүрдэнэ. Бид бөхөнгийн жишээг ашиглан судалгааг зурагласан. Шинжлэх ухааны судалгаа нь орон нутгийн иргэдийг оролцуулсан мониторингийг нэмэгдүүлснээр бүрэн дүүрэн хэрэгжих боломжтойг бид зөвлөж байна. Төв Азийн тууртны мониторинг судалгааны ирээдүй, одоо байгаа алдааг сайн тодорхойлох, мониторинг хөтөлбөр

болон арга зүйг илүүд үзэх, ажиллах хүчний боломжинд тулгуурлан мониторингийн үр бүтээмжийг хуваарилах, санхүү, бэлтгэл ажил, шинжлэх ухааны арга зүйг бүрэн эзэмших явдлыг дээшлүүлэх, дээжийн онол зэрэгт оршино.

**Tyler S. Kuhn and Arne Ø. Mooers** Missing saiga on the taiga. *Molecular Ecology* (2010) **19**, 4834–4836

Хамгааллын биологичид зүйлийн демограф түүхийг биотик ба абиотик хүчин зүйлийн эрсдэлтэй холбон үздэг бөгөөд демографийн өөрчлөлт нь тухайн явагдаж буй өөрчлөлтийн нөлөөнөөс урьдчилан сэргийлэхэд бидэнд туслах ёстой гэж ойлгодог. Үүнтэй уялдуулан судлаачид Плейстоценийн чулуужсан үлдэгдэлд тодорхойлогдсон зүйлүүдийн демограф түүхийг судлахын тулд эртний генетикийн мэдээллийг (aDNA) ашиглаж эхлэж байна. Гэсэн хэдий ч aDNA-гийн судалгаа нь популяцийн урт хугацааны хандлагыг цаг уурын өөрчлөлт, эртний хүний үйл ажиллагааны үүрэгтэй холбон тодорхойлох үндсэндээ чиглэж байна. Сүүлийн үеийн буюу Голоценийн үеийн популяцийн хандлага задлан шинжижлэх боломж муутайгаас маш муу судлагдсан. Кампос (2010a) ховордож буй бөхөн гөрөөсний өнөө үеийн демографик бүтцийг судлахдаа aDNA-гийн боломжийг онцлон үзсэн. Өнгөрсөн болон одоогийн демографийг харьцуулах цаг ирэх үед бүхэл бүтэн түүхийг бий болгох болно.

**von Meibom S., Vaisman A., Neo Liang S.H., Ng J., Xu H.** (2010). Saiga Antelope Trade: Global Trends with a Focus on South-east Asia. TRAFFIC project report to the CITES Secretariat. TRAFFIC Europe.

Хятад болон зүүн өмнөд Хятадын бөхөнгийн эврийн хэрэглээ, эврийн хууль бус олон улсын худалдаа нь энэ хээрийн гөрөөсний тоо толгойг бууруулах томоохон хүчин зүйл байж болох юм. Олон улсын TRAFFIC хөтөлбөрийн дагуу бэлтгэсэн уг тайланд дэлхийн бөхөнгийн эвэр, махны худалдааны тойм, Малайз, Сингапур, Хятадын зах зээлийн гүнд хийсэн анализыг оруулсан болно. Хятад улс бөхөнгийн эврийн хамгийн том импортлогч болохыг хувьд эврийн худалдааны нөөц, эдгээр нөөцийн менежментийг үзүүлсэн. Мөн Казахстан, ОХУ, Узбекстан зэрэг улсын бөхөнгийн популяцийн статус, хулгайн ангийн түвшин, хууль бус худалдааг мөн авч үзсэн.

Тайлангийн PDF хувилбарыг доорх вебсайтаас татаж авна уу: [www.iucn.org/dbtw-wpd/edocs/Traf-115.pdf](http://www.iucn.org/dbtw-wpd/edocs/Traf-115.pdf) болон <http://savesteppe.org/ru/archives/842>



**Янзагатай бөхөн**

### **Талархал**

Бөхөн хамгаалах нийгэмлэг сүүлийн 6 сарын турши бидний үйл ажиллагааг дэмжссэн доорх хүмүүст чин сэтгэлийн талархал илэрхийлье: Бөхөн хамгаалах үйл ажиллагааг үргэлжлүүлэн ивээн тэтгэсэн Узбекстан дахь боловсрол, олон нийтийн ажилд гайхалтай дэмжслэг үзүүлж байгаа Disney Foundation, Klub Pengian, Байгаль хамгаалах Витлей сан, Орос дахь бөхөн хамгааллыг санхүүжсүүлж буй Руффордын сан, Мухаммед Бен Заведын сан, Казахстаны Уралын төслийг дэмжин ажиллаж байгаа PTES, SOS fund, жижиг төслийн хөтөлбөрийг санхүүжсүүлж байгаа CIC зэрэг байгууллагуудад мөн чин сэтгэлийн талархлаа илэрхийлж байна. Бидний ажлыг үргэлжлүүлэн дэмжисж зөвлөгөө, санаа өвч байсан Зэрлэг амьтан хамгаалах сүлжээнийн ажилчид, Stacey Iverson нарт тусгайлан талархаж байна. Мөн энэ дугаарыг гаргахад дэмжслэг үзүүлсэн WCN, Мухамед бин Завед сан, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн Хятад дахь салбарыг талархал илэрхийлье.

Редакцийн зөвлөл. Хятад: А. Канг, WCS China ([akang@wcs.org](mailto:akang@wcs.org)) Г.Занг Гуанжоу дахь Британийн консулын ерөнхий газар ([gzhang@wcs.org](mailto:gzhang@wcs.org)); Казахстан: Профессор А. Бекенов & док Ю.А. Грачев, Зоологийн хүрээлэн ([teriologi@mail.ru](mailto:teriologi@mail.ru)), О. Климанова, Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг ([olga.klimanova@acbk.kz](mailto:olga.klimanova@acbk.kz)); Монгол: доктор Б.Лхагвасүрэн & Б. Чимэддорж, ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар ([lkhagvasuren@wwf.mn](mailto:lkhagvasuren@wwf.mn); [chimededorj@wwf.mn](mailto:chimededorj@wwf.mn)); ОХУ: Профессор Ю. Арилов, Калмыкын БНУ-ын Зэрлэг амьтан судлах төв ([kalmsaigak@elista.ru](mailto:kalmsaigak@elista.ru)) & док А. Лущекина, Экологи эволюцийн хүрээлэн ([rusmabcom@gmail.com](mailto:rusmabcom@gmail.com)); Узбекстан: Е. Бикова [ерөнхий редактор] & док А. Есипов, Амьтан судлалын хүрээлэн ([esipov@xnet.uz](mailto:esipov@xnet.uz)); Их Британи: Профессор Е.Ж. Милнер-Гулланд [зөвлөх редактор], Лондонгийн эзэн хааны коллеж ([e.j.milner-gulland@imperial.ac.uk](mailto:e.j.milner-gulland@imperial.ac.uk)).

Бүх өгүүллийг бидний хэрэглэгдэг 6 хэлний аль нэг дээр бичин үү. Өгүүллийг [esipov@xnet.uz](mailto:esipov@xnet.uz) хаягаар эсвэл редакторуудын аль нэг рүү илгээн үү. Жилд сэтгүүлийн хоёр дугаар хэвлэн гардаг. Материалыг [esipov@xnet.uz](mailto:esipov@xnet.uz) хаягаар эсвэл редакторуудын хэн нэгэнд илгээнэ үү. Сэтгүүл жилд хоёр удаа гардаг. Өгүүлэл бичих журмыг [www.saiga-conservation.com](http://www.saiga-conservation.com) хуудсаас эсвэл редакторуудаас англи болон орос хэл дээр авч болно. Хэрвээ танд асуулт гарвал өөрийн улсын Бөхөнгийн мэдээний редактортай эсвэл гүйцэтгэх редактор Елена Быковатай ([esipov@xnet.uz](mailto:esipov@xnet.uz)) холбогдоно уу.

Энэ дугаарыг онлайн хэлбэрээр [www.saiga-conservation.com](http://www.saiga-conservation.com), <http://saigak.biodiversity.ru/publications.html> болон <http://www.wildlifewarden.net/wcs/minisai-g-chinese.pdf> сайтуудаас pdf форматаар, эсвэл сэтгүүл хэлбэрээр хүсэлтийн дагуу редакторуудаас англи, казах, хятад, монгол, орос, узбек хэл дээр авч болно.